



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2015 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 6757

Улаанбаатар хот

Т.Золжаргалыг шилжүүлэн ажиллуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Засгийн газрын Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц орон тоог батлах тухай 2012 оны 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шинээр ажилд орох болон албан тушаал дэвшүүлэн ажиллуулахад мөрдөх нийтлэг журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 2015 оны А/668 дугаар захирамж, Авлигатай тэмцэх газрын 2015 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05/5395 тоот урьдчилсан мэдүүлэг хянасан тухай албан бичиг, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын байр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн хөдөө аж ахуй, үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Т.Золжаргалыг 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж мөн өдрөөс эхлэн Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн Хүнс, худалдаа үйлчилгээний мониторинг хариуцсан мэргэжилтнээр томилон ажиллуулсугай.

2. Т.Золжаргалтай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллахыг Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

3. Т.Золжаргалын ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга	О.Нарантуяа	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүд:	О.Уянга	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
	Э.Уянга	Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Я.Гантуяа	Бичиг хэргийн ажилтан
	Г.Мөнхчулуун	Архивын ажилтан
	Б.Халиун	Нярав

4. Т.Золжаргалын цалинг зохих журмын дагуу олгохыг ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА Б.БАДРАЛ

